



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДСЭНИЙ ХҮРЭЭЛЭН

#10
(19)

Сар тутмын хэвлэл

<http://www.mnier.mn>

Х сар



**"БОЛОВСРОЛ"
ЗАГВАР
(Нүүр 1-7)**



**ХУВЬСАЖ БҮЙ БОЛОВСРОЛ
ЗӨВЛӨГЧ СУРАГЧ
(Нүүр 8-10)**




**ҮЙЛ ЯВДАЛ, МЭДЭЭ
Нүүр (11-13)**

STRATEGIC INTELLIGENCE



Энэ удаагийн булангаар Дэлхийн эдийн засгийн форумд нийтлэгдсэн Германы Мюнхений Техникийн Их сургуулийн профессор, доктор Isabell M. Welpe, судлаач Felix Rank нарын удирдан боловсруулсан "БОЛОВСРОЛ" загварыг танилцуулж байна. Холбоостой танилцана уу





Техник, технологийн хөгжил, дэвшил боловсролыг өөрчилж, орчин цагийн ажил, мэргэжилд шаардлагатай ур чадварууд шинэчлэгдсээр байна.

Насан туршдаа суралцаж, дасан зохицох чадвартай хүн болгонд тогтмол (байнгын) хүргэж чадах арга хэрэгсэлтэй, ирээдүйд бэлэн байх /гамшиг болон аюулгүй байдал/ боловсролтой болох нь 21-р зуунд нэн шаардлагатай байна.

Тусгайлсан боловсролтой хүний нөөц, ажиллах техник болон ажил олгогчийн хооронд тасалдаад байгаа холбоос дээр анхаарч, ажлын байр дээр шаардлагатай байгаа чадваруудад тусгайлан анхаарах хэрэгтэй.



1. ЗӨӨЛӨН УР ЧАДВАРУУД



Дэлхийн эдийн засгийн форумын 2020 оны тайлангаар технологийн дэвшлээс улбаалан 2025 он гэхэд 85 сая ажлын байр устах магадлалтай ч тус хөгжлийг дагаад 97 сая ажлын байр нэмэгдэх магадлалтай гэж үзсэн байна.

Ирээдүйд урт хугацаанд ажлын байраа хадгалахын тулд цор ганц цогц ур чадвар хангалтгүй гэж үзэж байгаа ч зөөлөн ур чадвар нь ажлын байрны зах зээлийн хэрэгцээ, шаардлагын өөрчлөлтөд дасан

зохицоход нэн шаардлагатай байх болно.

Зөөлөн ур чадваруудыг суурь боловсролоор хөгжүүлж, дээд боловсрол болон насан туршийн боловсролоор сайжруулах хэрэгтэй.

Зөөлөн ур чадварын суурийг сайн эзэмшүүлснээр боловсролын систем нь ирээдүйн ажлын байранд дасан зохицох чадварын хурдасгуур болоод зогсохгүй амьдралын чанарыг дээшлүүлнэ.

2. БОЛОВСРОЛЫН ИННОВАЦ



Ковид-19 цар тахал бидэнд боловсролыг хүргэх шинэ, арга хэрэгсэл чухал шаардлагатай байгааг харуулсан. Цар тахлаас өмнө ч технологийн инновац боловсролын материал боловсруулах, боловсролын контентыг түгээх, суралцагчид тус материалыг хэрхэн ашиглах, боловсролын үр дүнг үнэлэх арга замуудыг өөрчилж эхэлсэн.

Amplify, Knewton зэрэг технологийн компаниуд сурах бичгийг цахим хэлбэрт оруулж, тоглоомд суурилсан сургалтыг хөгжүүлж эхлээд байсан бол Coursera, edX, болон Khan

Academy боловсролыг цахимаар (MOOCs) олгох хувьсгалыг эхлүүлэх арга замуудыг хайж эхэлсэн. 2020 оны дунд үе гэхэд дэлхийн хүн амын тал хүрэхгүй хувь (71 орны) нь алсын зайнаас суралцах интернэтээр хангагдсан байна гэж UNICEF-ээс зарласан.

Иймээс инновац нэвтрүүлэх туршилт, хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалтыг стратегийн үүднээс олгосноор үр дүн нь сайн гарч болох юм. Мөн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа боловсролын инновацад чухал юм.

Боловсролын инновац нь дан ганц боловсролыг хүргэх арга замуудын хүрээнд яригдахаас гадна сургуулийн хөтөлбөрийн хүрээнд яригдах ёстой.

Сурган хүмүүжүүлэх ухаан нь инновацын хувьд боловсорч гүйцсэн талбар хэдий ч алслагдмал бүлэгт тогтмол хүрч чадахгүй нөхцөл үүсдэг.

Боловсролын салбарт инновац нэвтрүүлэх нь чухал ч үр дүнтэй байдлыг нь давхар хянаж байх нь зүйтэй.

3. НАСАН ТУРШИД СУРАЛЦАХ ЗАМНАЛ



Боловсрол ихэнхдээ амьдралын эхний үе шатуудад дуусчихдаг нь ажилчид болон ажил олгогч нарт хохиролтой байдаг.

McKinsey & Company фирмийн судалгаагаар ирэх арван жилд биеийн хүчний болон давтагддаг ажлын байрнуудын хэрэгцээ, шаардлага 30 хувиар буурч технологийн ур чадвар шаардагдсан

ажлууд 50 гаруй хувиар нэмэгдэнэ гэж үзсэн.

Уламжлалт ажлын байрны зах зээл нуран унаснаар хувь хүний карьерын замнал өөрчлөгдөж насан туршдаа суралцах хэрэгцээ гарч байна.

Дэлхийн эдийн засгийн форумын тайлангаас үзэхэд 25-аас доош насны хүмүүсийн 84 хувь нь чадвараа боловсролоор дамжуулан сайжруулдаг хандлагатай бол 25-аас дээш насны хүмүүсийн

хувьд 45 хувь нь чадварыг боловсролоор дамжуулан хөгжүүлэх сонирхол нь буурдаг гэсэн үр дүн гарсан байна.

Иймээс 25-аас дээш насны хүмүүст шинэ ур чадварыг сургахын тулд үндэсний хэмжээнд хамруулах (framework) болон олон нийтийн төвүүдээр дамжуулан насан туршийн боловсрол олгохыг ЮНЕСКО санал болгожээ.

4. ЧАНАРТАЙ СУУРЬ БОЛОВСРОЛ



Амьдрал дахь тэгш боломж нь суурь боловсролд тэгш хамрагдсанаар илэрдэг. Дэлхийн улс орнуудын 10 хүрэхгүй хувь нь боловсролд бүрэн хамруулахад чиглэсэн хуультай.

Ядуу буурай орнуудын 40 хувь нь "Эрсдэлд байгаа суралцагч нар"-т дэмжлэг үзүүлж чаддаггүй байна. /2020 онд хэвлэгдсэн ЮНЕСКО-ийн тайлан/ ЮНИСЕФ-ийн тайланд дурдсанаар хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн 175 сая гаруй хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй хэвээр байна.

Дэлхийн улс орнуудын 2/3-д нь бага боловсрол дахь хүйсийн тэгш байдал хад-

-галагдаж байгаа бол дунд ангиас эхлээд эмэгтэй хүүхдүүдийн тоо цөөрч байна.

ЮНЕСКО-ийн НҮБ-ын Мянганы хөгжлийн бодлогын зорилтууд хийсэн үнэлгээ дээр 2030 он хүртэлх суурь боловсролын шалгууртаа хүрэхийн тулд нэмэлтээр 22 тэрбум долларыг жил бүр зарцуулах хэрэгтэй гэж үзэв.

Эндээс харахад санхүүгийн болон өгөгдөл цуглуулах шинэ моделиуд хэрэгтэй байгаа нь харагдаж байна. Ялангуяа алслагдмал бүс нутагт амьдардаг эсвэл нүүдлийн аж ахуйтай өрхийн хүүхдүүдийн хувьд энэ асуудлыг шийдэхэд технологийн инновац нэг гарц нь байж болох юм.

5. ТАСРАЛТГҮЙ БОЛОВСРОЛ



Боловсролын систем техникийн болон мэргэжлийн сургалтыг орхигдуулах нь элбэг.

Ажил олгогч нарын хувьд ажлын байрны шаардлага болон ажилчид хоорондын ур чадварын ялгаа улам ихсэж байгаа нь аюулын харанга дэлдсээр ирсэн бол Улс орнуудын хувьд олон улсад өрсөлдөхийн тулд техникийн авьяастай хүмүүсийг түлхүү анхаарах ёстой гэж үзэх болсон.


Deloitte-ийн үзсэнээр 2018-2028 оны хооронд үйлдвэрлэлийн салбарт 2.4 сая ажлын байрны орон тоо хоосон байснаар эдийн засагт 2.5 их наяд долларын хохирол учруулна гэж тооцоолсон. Боловсрол болон сургалтын системд тохирсон өөрчлөлтийг хийхгүй бол энэ байдал улам л дордох болно.

2019 онд Герман улс засгийн газар, аж үйлдвэрийн салбаруудын ашиг сонирхол,

үйлдвэрчний эвлэл болон ажилтнуудын харилцан зохицол, санхүү болон чадварын мэдээллийг хамруулсан нэгдсэн соёл дээр суурилсан үндэсний тасралтгүй суралцах стратегийг танилцуулсан.

Цагаа олсон, зөв зүйтэй карьерын зөвлөмж залуучуудыг сургуулийн жилүүдээс ажлын жилүүдэд амжилттай шилжихэд туслах болно.

6. ЦАХИМ СУРАЛЦАХУЙ БА STEM



Цахим ур чадвар чухал ч техник, технологийн ололт, амжилт дээр ёс зүйг анхаарах нь чухал.

Ковид-19 цар тахлын үеэр технологи гэр бүлийг болон ажлын хамт олныг хооронд нь холбож өгсөн нь ойрын ирээдүй хэрхэн цахимжсан байхыг тод харуулсан юм. Цахим болон уламжлалт хосолсон шинэ тогтолцоо нь өөрийн гэсэн сорилт аваад тогтохгүй анхнаасаа байсан тэнцвэргүй байдлыг улам хүндрүүлж болзошгүй байна.

Орчин үеийн ажлын байранд өсөж дэвжихийн тулд цахим суралцахуй болон /STEM/ чадваруудыг бага наснаасаа хөгжүүлэх шаардлагатай болж байна. Цахим ур чадвар нь суурь цахим мэдлэгээр эхэлж, технологийг ашиглах болон өгөгдөлтэй ажиллах ёс зүйн шаардлагууд үүсэж байна.

АНУ-ын Хөдөлмөрийн яамны судалгаагаар 2016–2026 оны хооронд хамгийн ихээр хөгжиж буй 20 ажил мэргэжлийн ихэнх нь математик болон инженерийн мэдлэг тодорхой хэмжээнд шаардана гэж үзсэн. Мөн CEDEFOP 2020-2030 оны хооронд Европын холбоонд шинжлэх ухаан, мэдээллийн технологитой холбоотой ажиллах хүч 11 хувиар нэмэгдэнэ гэж тооцоолсон байна.

Англи хэлний “Зөвлөгч сурагч” хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээг батлах тухай” 372 дугаар тогтоолд заасны дагуу БСҮХ-ээс төрийн өмчит ЕБС-ын ахлах ангийн англи хэлний сургалтыг дэмжих зорилгоор суралцагчдад зориулсан англи хэлний нэг жилийн эрчимжүүлсэн

“ЗӨВЛӨГЧ СУРАГЧ” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь хичээлийн бус цагаар хүүхэд хүүхдэдээ англи хэл зааж, англи хэлний багшийн удирдлага дор сурагчид хамтран суралцдаг Монголын анхны хөтөлбөр бөгөөд 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдаж, 15 сургуульд хэрэгжиж байна.

Нийслэлийн Ерөнхий боловсролын 60 дугаар сургуулийн 11В ангийн сурагч **Аюурдоржийн Галсайхан**



Нийслэлийн Ерөнхий боловсролын 30 дугаар сургуулийн 12Б ангийн сурагч **Энхжаргалын Бат-Оргил**




Баянхонгор аймгийн Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 11Б ангийн сурагч **Батцэнгэлийн Ундралмаа**



Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 11А ангийн сурагч **Мягмарсүрэнгийн Болор-Эрдэнэ**



Нийслэлийн Ерөнхий боловсролын 147 дугаар сургуулийн 10В ангийн сурагч **Санжаагийн Хулан**



Дорнод аймгийн
Хэрлэн сумын
Ерөнхий
боловсролын
8 дугаар сургуулийн
11Г ангийн сурагч
**Номин-Эрдэнийн
Мөнгөнхүү**



Дорноговь аймгийн
Сайншанд сумын
лаборатори 2 дугаар
сургуулийн 10Б ангийн
сурагч **Шуургын Дөлгөөн**



Хөвсгөл аймгийн
Тосонцэнгэл сумын
Ерөнхий боловсролын
сургуулийн
10В ангийн сурагч
**Бямбадоржийн
Мөнх-Ундрах**



Хөвсгөл аймгийн
Цагааннуур сумын
Ерөнхий боловсролын
сургуулийн
10А ангийн сурагч
Ганзоригийн Уранзаяа



Өмнөговь аймгийн
Даланзадгад
сумын Ерөнхий
боловсролын
5 дугаар
сургуулийн 11А
ангийн сурагч
**Отгонбаярын
Пүрэвжаргал**






Нийслэлийн Ерөнхий боловсролын 92 дугаар сургуулийн 11А ангийн сурагч **Оюубаатарын Энхжин**



Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 11А ангийн сурагч **Алтанчимэгийн Мөнхтөр**



Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 1 дүгээр сургуулийн 11В ангийн сурагч **Пүрэвнямын Хулан**




Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургуулийн 12Г ангийн сурагч **Наранцэцэгийн Ууганжаргал**



Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 10В ангийн сурагч **Болдбаярын Нарансолонго**

“WELCOME” хөтөлбөр

БСҮХ-ийн Гадаад хэлний төв 2023-2024 оны хичээлийн жилд Ахлах ангийн сурагчдад зориулсан англи хэлний нэг жилийн эрчимжүүлсэн “WELCOME” хөтөлбөрийг дахин зарласан бөгөөд сонгон шалгаруулалт амжилттай явагдаж, 17 сургууль дээр тус хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна.



1. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн англи хэлний багш **Ханатын Толхын**
2. Баянхонгор аймгийн Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн англи хэлний багш **Гэндэнсүрэнгийн Оюунзаяа**
3. Баянхонгор аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш **Алтантуяагийн Долгор**
4. Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш **Батцэнгэлийн Лхамноржмаа**
5. Завхан аймгийн Түдэвтэй сумын ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш **Намхайнямбуугийн Цэнд-Аюуш**
6. Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн англи хэлний багш **Батдэлгэрийн Ариунгэрэл**
7. Орхон аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын 13 дугаар сургуулийн англи хэлний багш **Чулууны Ариунжаргал**
8. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн англи хэлний багш **Энхмөнхийн Дашням**
9. Өвөрхангай аймгийн Хархорин сумын ерөнхий боловсролын Гүнзгий сургуулийн англи хэлний багш **Нямсүрэнгийн Батжаргал**
10. Өвөрхангай аймгийн Хархорин сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн англи хэлний багш **Надмидын Одгэрэл**
11. Өмнөговь аймгийн Даланзадгад сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн англи хэлний багш **Өлзийсүрэнгийн Сувдаа**
12. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн англи хэлний багш **Бүрэнбадрахын Энхзул**
13. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш **Нямсүрэнгийн Энхцэцэг**
14. Нийслэлийн ерөнхий боловсролын 13 дугаар сургуулийн англи хэлний багш **Цэрэн-Очирын Цэрэнпагма**
15. Нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургуулийн англи хэлний багш **Батсайханы Бадамсүрэн**
16. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Ирээдүй XXI зуун сургуулийн англи хэлний багш **Дагвадоржийн Одончимэг**
17. Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш **Цэрэндоржийн Саранцэцэг**

“Өнгөрснөө эргэцүүлэн, ирээдүйд шилжих нь” ДЭЛХИЙН ӨВ ХЭЛНИЙ ЧУУЛГАН



АНУ дахь өв хэлний сургуулиудын холбоо болон Вашингтоны Америкийн Их сургуулиас жил бүр хамтран зохион байгуулдаг Өв хэлний чуулган “Өнгөрснөө эргэцүүлэн, ирээдүйд шилжих нь” сэдэвтэйгээр танхим болон цахим хосолсон хэлбэрээр явагдав. Тус чуулганд 55 орны төрөлх хэлний багш нарыг төлөөлөн 200 гаруй хүн оролцсоноос Монгол Улсаас БСҮХ-ийн ЭША Ж.Гэрэлмаа, хилийн чанад дахь монгол багш нараа төлөөлөн Бельги улсаас Ш.Чимгээ, Швед улсаас Н.Болормаа, Тайвань улсаас Б.Буянжаргал,

Ц.Түмэнжаргал нар оролцож, 2 өдрийн турш дэлхийн өв хэлний багш нар туршлагаа хуваалцах хэлэлцүүлэгт оролцлоо.

10 дахь жилдээ зохион байгуулж буй энэхүү чуулганд анх удаа Монгол Улсын төлөөлөл оролцож, хэлний бүртгэлийн санд нь монгол хэлийг шинээр бүртгүүлсэн нь онцлох үйл явдал боллоо.



“ҮНДЭСНИЙ БИЧИГ” аппликейшны туршилт



Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ийн хүрээнд Төрийн албан хаагчдын монгол бичгийн мэдлэг чадварыг сайжруулах, сургагч багш нарын заах аргазүй, ур чадварыг дэмжих зорилготой боловсруулсан интерактив “ҮНДЭСНИЙ БИЧИГ” аппликейшныг Монгол Улсад анх удаа Боловсролын судалгааны


үндэсний хүрээлэнгийн Монгол хэл бичгийн судалгаа аргазүйн төвөөс хийж гүйцэтгэсэн байна.

Энэхүү аппликейшн нь насанд хүрэгчдэд зориулагдсан бөгөөд орон зай, цаг хугацаа үл хамааран, өөрийн хурдаар суралцах боломжтой, идэвхтэй хариу үйлдэл бүхий сорилуудаар сургалтын үр дүнгээ хянан, монгол бичгийн чадвараа ахиулж, түвшнээ дээшлүүлэх боломжтойгоороо онцлог юм.




Тус аппликейшныг нийтийн хүртээл болгох, төрийн албан хаагчдад хэрэглээнд нэвтрүүлэхийн өмнө олон улсын хүртээмжийн WCAG стандарт болон Playstore, Appstore-д оруулах шаардлагуудыг хангасан эсэх, хөгжүүлэлтэд дүгнэлт гаргах нэг сарын хугацаатай туршилт хийлээ.

Туршилтад төрийн албаны төлөөлөл 6 байгууллага (БШУЯ, ГХЯ, ЦХХХЯ, БЕГ, БСҮХ, СУИС)-ын 109 албан хаагч оролцож, 1 сарын турш ашигласны үндсэн дээр асуулга болон хяналтын хуудсаар санал өгөв. Мөн аппликейшны “Санал” цэсээр нийт 2000 орчим санал ирснийг нэгтгэн боловсруулж, саналын дагуу боломжит сайжруулалтыг хийж гүйцэтгэлээ.



Аппликейшны техникийн шаардлага хангаж, хэвийн ажиллаж буй эсэхэд БСҮХ-ийн Өгөгдөл боловсруулалт, цахим судалгаа хөгжүүлэлтийн секторын эрдэм шинжилгээний ажилтнууд ажиллаж, шинжилгээ хийж сайжруулах санал, дүгнэлтийг гаргахаар төлөвлөж байна.

Аппликейшны ажиллагааны үнэлгээ



Дижитал сурах бичиг боловсруулах чиглэлээр Польшийн Гданск хотод туршлага судлах сургалт үйл ажиллагаанд оролцлоо.

Монгол улсын БШУЯ-ны санаачилгаар БСҮХ, БҮТ, БМТТ-аас бага ангийн сурах бичгүүдийг интерактив цахим хэлбэрт хөрвүүлж буй багийн төлөөлөл 2023 оны 10 сарын 09-20 ны өдрүүдэд Польшийн Гданск хотод туршлага судлах сургалт үйл ажиллагаанд хамрагдав.

Тус багийнхан хоёр долоо хоногийн хугацаанд Learnetic компанийн сургалт, контент үйлдвэрлэлийн платформуудын онцлог, дэлгэрэнгүй танилцуулга, үйл ажиллагаатай биечлэн танилцлаа. Цаашлаад дижитал интерактив сурах бичиг нь хэвлэмэл сурах бичигтэй агуулга, үг хэллэг найруулгын хувьд яв цав оновчтой, сурагчдын нас

сэтгэхүйн онцлогт тохирсон, Монгол ахуй соёлыг багтаан харуулсан, олон төрөлт шинэлэг даалгаврын төрлүүдийг багтаасан, тэдгээрийг хүргэж буй технологи, загварчлалын шинэлэг тохиромжтой байгаа эсэх дээр судалгаа шинжилгээ хийн хамтран ажиллалаа.



Мөн Learnetic компанийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй төслүүд, олон улсад чиглэсэн боловсролын дижитал платформууд, технологийн хэрэгслүүдийн талаар туршин судалж, ялангуяа Монгол улс албан ёсны эрхтэйгээр ашиглах болсон mAuthor контентын платформ болон mCourser LMS-н загвар, зохион байгуулалт,

Польш улсад болон олон улсад хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай танилцан, холбогдох мэдлэг, техникийн чадваруудаас суралцаж бага боловсролын хэвлэмэл сурах бичгүүдийг дижитал болгоход гарч байсан хүндрэлүүд, агуулга, даалгаврыг интерактив болгоход зайлшгүй өөрчлөн сайжруулах боломжуудыг эрэлхийлэн ажиллаад ирлээ.

Хүний нөөцийг чадавхжуулах сургалт.

БШУЯ-ны захиалгаар Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн, Кембриджийн сургагч багш нартай хамтран 2023 оны 10 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд “Сурах бичиг, сургалтын материал боловсруулах, хэвлэх чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах” сургалт зохион байгууллаа.

Сургалтад БСҮХ, БЕГ, БҮТ, БМТТ, МУИС, МУБИС, СӨББ, ЕБС, хэвлэлийн газар, төрийн бус байгууллагын төлөөллийн нийт 70 орчим хүн хамрагдсан.



Биеийн тамир спортын тэмцээн

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн хамт олон оюуны алжаалаа тайлж, нэг өдрийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор гар бөмбөг, хөгжөөнт буухиа, даам, дартс гэсэн 4 төрөлт тэмцээнийг 2023 оны 10-р сарын 27-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Энэ арга хэмжээнд байгууллагын эрдэм шинжилгээний ажилтан, албан хаагчид бүгд идэвхтэй оролцож, нэг өдрийг баяр хөөр, амжилт бүтээлээр дүүрэн дурсамжтай өнгөрүүллээ.

